



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 4/89

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Буянт сумын Норжинхайрхан багт баригдсан “Мэдээлэл холбооны 15 метр өндөртэй цамхгийн ажил”-ийг хувийн хөрөнгөөр “Алтан арал хөгжил” ХХК гүйцэтгэж дууссан тул ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Төгөлдөр (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Б.Бат-Оюун (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)

Г.Алтанхуяаг (“Мэдээлэл холбоо сүлжээн” ТӨХХК-ийн ерөнхий инженер)

Ш.Мөнхзаяа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн Хяналтын инженер)

Б.Одсүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн Хяналтын инженер)


С.Батболд (“Алтан арал хөгжил” ХХК-ийн инженер)

Нарийн бичгийн

дарга: С.Өнөржаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Буянт сумын Норжинхайрхан багт баригдсан “Мэдээлэл холбооны 15 метр өндөртэй цамхгийн ажил”-ыг ажлын тоо хэмжээ, төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Төгөлдөр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Э.УРТНАСАН